

# БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/050/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2026 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ужим Алтай Аудит ХХК-ны Захирал: Г.Ганболд
	Утас: 99117121 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦЭНГЭЛ СУМЫН  
ХҮҮХДИЙН ХОЁР ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Х.ЖАЙНАГУЛ ТАНАА

2026.02.25 № 170  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Цэнгэл сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэг нь 2025 онд 1,131.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,071.8 сая төгрөг зарцуулж, 94.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

832605000344

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

**ХОЁР .АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,131,219,000.00</b>	<b>1,071,818,521.28</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,131,219,000.00</b>	<b>1,071,818,521.28</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,131,219,000.00</b>	<b>1,071,818,521.28</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>875,183,600.00</b>	<b>842,975,480.28</b>
210101	Үндсэн цалин	561,323,700.00	542,435,481.27
210102	Нэмэгдэл	294,570,100.00	263,213,884.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт		21,115,000.00
210104	Урамшуулал	19,289,800.00	16,211,115.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>108,642,200.00</b>	<b>82,272,941.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	73,676,200.00	66,954,841.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,741,500.00	7,763,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,370,700.00	1,259,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,370,700.00	1,259,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,483,100.00	5,036,400.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,251,700.00</b>	<b>41,251,700.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,718,000.00	10,718,000.00
210302	Түлш, халаалт	28,866,700.00	28,866,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,667,000.00	1,667,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>72,916,800.00</b>	<b>72,203,600.00</b>
210502	Хоол, хүнс	72,916,800.00	72,203,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>999,900.00</b>	<b>999,900.00</b>
210604	Урсгал засвар	999,900.00	999,900.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,564,800.00</b>	<b>3,560,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,800.00	3,560,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>28,660,000.00</b>	<b>28,554,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,297,300.00	22,192,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,362,700.00	6,362,600.00
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,131,114,000.00</b>	<b>1,012,368,900.00</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>974,696,100.00</b>	<b>970,117,300.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	974,696,100.00	970,117,300.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>42,251,600.00</b>	<b>42,251,600.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	42,251,600.00	42,251,600.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>114,166,300.00</b>	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	114,166,300.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		125,429,764.75
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		65,980,143.47

Цэнгэл сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>35.00</b>	<b>35.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>160.00</b>	<b>160.00</b>
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>35.0</b>	<b>35.0</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	18.00	18.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00

## **ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 123.4 сая төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад 123.4 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. *Залруулсан алдаа:*

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих 118.8 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгалгүйгээр алдаатай тайлагнасан байна.
2. Мөнгөн гүйлгээний тайланд 4.6 сая төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тусган харуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### **5.2 Албан шаардлага**

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй болно.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### ***1. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал***

##### **1.1 Илрүүлэлт:**

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/46 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн тооллого хийх комисс нь тооллого хийхдээ нийт 13.9 сая төгрөгийн аж ахуйн болон бусад хангамжийн материалыг дутуу тоолсон байна. Мөн тавилга, эд хогшил, машин тоног төхөөрөмжийн тооллогыг хооронд нь сольж, бүрэн бус тооллого хийсэн бөгөөд тооллогын бүртгэлийг зохих журмын дагуу баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"-гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### **1.2 Өгсөн зөвлөмж:**

Цэнгэл сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Жилийн эцсийн тооллогыг хууль, журмын дагуу иж бүрэн, үнэн зөв зохион байгуулж, тооллогын бүртгэлийг шаардлагын дагуу баримтжуулах, мөн энэ чиглэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.

*Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТГТ-г зөрүүтэй тайлагнасан	1	118,850.1	1	118,850.1			1	118,850.1				
МГТ-д биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тусган харуулаагүй байна.	1	4,636.0	1	4,636.0			1	4,636.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>123,486.1</b>	<b>2</b>	<b>123,486.1</b>			<b>2</b>	<b>123,486.1</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн тооллогыг иж бүрэн, үнэн зөв хийж тооллогын бүртгэлийг баримтжуулах	1	13,962.7					1	13,962.7				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>13,962.7</b>					<b>1</b>	<b>13,962.7</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Цэнгэл сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								